



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

I.34.ХЭЛЭЛЦСЭН нь: Дахин төлөвлөлтийн тухай

Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-109/15, 2021 оны 01-017-109/16 дугаар актаар тогтоогдсон, нийт 2,761,095,661.00 (хоёр тэрбум долоон зуун жаран нэгэн сая ерэн таван мянга зургаан зуун жаран нэгэн) төгрөгийн балансын үнэ, нийт 382,147,076.43 (гурван зуун наян хоёр сая нэг зуун дөчин долоон мянга далан зургаан төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Хичээлийн 2-р байр (Хилийн албаны сургуулийн барилга), Хичээлийн 4-р байр (цэцэрлэг) нь анхны зураг төсөлгүй, аж ахуйн аргаар баригдсан, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтэд даацын тоосгон ханын бат бэх буурсан, газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээ авах боломжгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй гэж дүгнэгдсэн нь Барилгын тухай хуулийн 11.1.1, 11.1.5 даалтад заасан барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюулд учруулахгүй, бат бэх тогтвортой байх үндсэн шаардлага болон барилга байгууламж ашиглагчдын аюулгүй байдлыг хангах шаардлагуудыг зөрчих эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Иймд Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн болон Хилийн албан сургуулийн ашиглалтын үйл ажиллагааг 2021.12.06-ны өдрөөс энэхүү актаар зогсоосон тухай дүгнэлт гарсан байна.

Дотоод хэргийн их сургуулиас ирүүлсэн 2022.01.04-ний 01/12 дугаар албан бичигт "...Засгийн газрын 2010 оны 149 дүгээр тогтоолоор баталсан "Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл", 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалтын хүрээнд Дотоод хэргийн их сургуулийг хотхоноор хөгжүүлэх ажилд Засгийн газраас 1 тэрбум төгрөгийг 2021 оны улсын төсөвт тусгасны дагуу Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад шалгарсан гүйцэтгэгч компани техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байгаа тухай мэдэгдсэн тул дээрх объектыг дахин төлөвлөлтөд хамруулах тухай хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Дотоод хэргийн их сургуулийн Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Хилчний гудамжны байршилд шинэ барилга барих зорилгоор Хичээлийн 2-р байр (Хилийн албаны сургуулийн барилга), Хичээлийн 4-р байр (цэцэрлэг)-ыг дахин төлөвлөлтөд

132002035

